



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: 7052 2533, Факс: (976) 7052 2530
Цахим шуудан: zdtg@dornogovi.gov.mn,
Цахим хуудас: www.dornogovi.gov.mn

"СОЛОНГОС МОНГОЛЫН
ХӨГЖЛИЙН ТӨВ"-ИЙН
ЗАХИРАЛ ЁН РЭ КИМ ТАНАА

2024.04.25 № 01/572
танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Таны энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Дорноговь аймагт сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар болон хувийн хэвшлүүдээс хэрэгжүүлж буй тэргүүлэх чиглэлийн томоохон төслүүд болох Нефтийн үйлдвэр, Алтанширээт аж үйлдвэрийн парк, Гэрэлт говь аж үйлдвэрийн парк зэрэг уул уурхайн баяжуулах, боловсруулах үйлдвэрүүд, Замын-Үүдийн чөлөөт бүс, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам, мах, сүү, арьс шир, боловсруулах, ноос ноолуур угаах үйлдвэр, эрчим хүч, мод үржүүлэг, эрүүл мэнд, боловсролын чиглэлийн нийт 20 гаруй төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд шинээр ажлын байрууд бий болж тэргүүлэх чиглэлийн дагуу нэн шаардлагатай инженер, мэргэжилтнүүдийг бэлтгэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Иймд цаашдаа хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар орон нутагт дараах мэргэжлүүдээр хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай байна. Үүнд:

Тэргүүлэх мэргэжил: Био-анагаах ухаан, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, Уламжлал анагаах ухааны эмийн ургамал судлал, Мэдээлэл технологи-IT, Барилгын инженерчлэл, Мал аж ахуй

Эрэлттэй мэргэжил: Төмөр замын мэргэжлүүд, Цахилгаан, сантехник, баяжуулах, геологи, уул уурхай, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, технологич инженерүүд, Лаборант, Лабораторийн техникч, Химич, Хими, биологийн багш, Сэтгэл судлал, сэтгэл зүйл, Хоол зүйч, Хөдөлгөөн засалч, Нүүр амны судлал эрүүл ахуйч, Дүрс оношилгооны техникч, Сувилахуй, Эм найруулагч, Бага эмч, Эх барихуй зэрэг мэргэжлүүд байна.


Иймд "Солонгос Монголын хөгжлийн төв"-тэй дараах чиглэлээр хамтран ажиллах хүсэлтэй байна.

- Ахлах ангийн сурагчдын солонгос хэлний бэлтгэлд сургах, багш, оюутан, залуучуудыг солонгос хэлний сургалтын тусгай хөтөлбөрт хамруулах;
- Эрэлттэй, тэргүүлэх мэргэжлээр төгсөгчдийг БНСУ-д тэтгэлгээр сургах;
- Солонгосын соёл, боловсролын төв байгуулах;
- Багш, оюутан, сурагч солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулах чиглэлээр шинэ шилдэг сургалтын хөтөлбөр бүхий боловсролын байгууллагуудын сайн туршлагыг харилцан судлах, шат дараатай нэвтрүүлэх;
- Зуны урт болон богино хугацааны суралцагч, багш нар, төрийн албан хаагчдыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх.

4424900311

Дорноговь аймаг нь олон Улсын стандарт шаардлагад нийцсэн чанартай боловсролыг олгох, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх зорилтыг дэвшүүлж байгаа тул дэмжиж хамтран ажиллана уу.

Хүндэтгэсэн,



О.БАТЖАРГАЛ